БАТЛАВ
БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА И.БАТТӨГС

2024 оны 02 дугаар сарын 15 өдөр

# ТОХИЖИЛТЫН АЖИЛ (УЛААНБААТАР ХОТ, БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ, 8, 10 ДУГААР ХОРОО)-ЫН ЗУРГИЙН ДААЛГАВАР

2024 оны 02 дугаар сарын 07-ны өдөр Улаанбаатар хот

| | | |
|---|---|---|
| 1 | Зураг төсөл боловсруулах үндэслэл | - Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 15 дугаар хуралдааны 80 дугаар тогтоол;<br>- Хот байгуулалт хөгжлийн газрын ХТХ2017/13-271 дугаартай төлөвлөлтийн даалгавар; |
| 2 | Байршил, эдэлбэр газрын хэмжээ | - Баянзүрх дүүргийн 8, 10 дугаар хороо, Ботаникийн эцсийн буудал 1298 м2 талбайд тохижилт хийх; |
| 3 | Зориулалт, хүчин чадал | <u>Орчны нөхцөл байдалд уялдуулан</u><br>- Ногоон байгууламж;<br>- Тохижилт;<br>- Гэрэлтүүлэг; |
| 4 | Зураг төслийн бүрдэл | <u>Зураг төсөлд тавигдах шаардлага:</u><br>- Тохижилтын элементүүдийг норм дүрмийн дагуу төлөвлөх ба ерөнхий харагдах байдлыг 3D буюу 3 хэмжээст зураглалаар гүйцэтгэх;<br>- Зураг төслийг хот байгуулалтын мэдээллийн санд хүлээж авахад тавигдах шаардлага;<br>а. Хот байгуулалтын мэдээллийн сангийн стандартыг мөрдөх;<br>б. Хийгдэж буй төслийн дэвсгэр зургийн WGS-84, UTM буюу солбицлын нэгдсэн тогтолцоонд хийж гүйцэтгэх; |
| 5 | Зураг төсөл зохиох үе шат, хугацаа | - Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгох; |
| 6 | Зураг төслийн байгууллага | - Захирамжийн дагуу сонгон шалгаруулалтаар шалгарсан байгууллага байх; |
| 7 | Хөрөнгө оруулагч (захиалагч) байгууллага | - Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар; |
| 8 | Инженерийн хангамж | - Эрх бүхий байгууллагаас холбогдох техникийн нөхцөлийг авч, техникийн нөхцөлийн дагуу зураг төсвийг боловсруулан угсралтын ажлыг хийж гүйцэтгэх; |

| | | |
|---|---|---|
| 9 | Онцгой нөхцөл | Анхаарах зүйл:<br>- Орчин нөхцөл байдалд уялдуулан сандал, саравч, хогийн сав, төлөвлөхдөө бат бөх чанартай материал сонгох мөн хавсралтад заасан стандарт эсвэл дүйцэхүйц материал, чанарыг хангах;<br>- Тендерт үнийн санал ирүүлэхдээ газар дээр нь судалж, ажлын тоо хэмжээг тооцож ирүүлэх;<br>- Ажлын зураг төсвийг боловсруулж, магадлалаар баталгаажуулсны дараа угсралтын ажлыг эхлүүлэх;<br>- Явган хүний замын чиглэл, хөдөлгөөний эрчмийг тооцоолох;<br>- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангах;<br>- Автомашины дугуй цохигч тооцоолох;<br>- Борооны ус зайлуулах байгууламж тооцох; |
| 10 | Төлөвлөлтөд тавигдах шаардлага | Дараах байгууллагуудтай заавал зөвшилцсөн байна:<br>- Хот байгуулалт, хөгжлийн газар;<br>- Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар;<br>- Холбогдох бусад байгууллагатай; |
| 11 | Ерөнхий төлөвлөгөө, Зураг төсөв боловсруулах | Хууль тогтоомжууд:<br>- Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль;<br>- Барилгын тухай хууль;<br>- Газрын тухай хууль;<br>- Хот байгуулалтын тухай хууль;<br><br>Норм, нормативууд:<br>- “Хотын стандарт-Ногоон байгууламжийн төлөвлөлтөд тавих шаардлага” UCS 0801A стандартыг мөрдөх;<br>- “Хотын стандарт-Гэрэлтүүлгийн тоног төхөөрөмжид тавих шаардлага” UCS 1901B, UCS 1902A стандартыг мөрдөх;<br>- “Хотын стандарт-Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавих шаардлага” UCS 0901B стандартыг мөрдөх;<br>- “Хотын стандарт-Саравч, сүүдрэвчинд тавигдах ерөнхий шаардлага” UCS 1404B стандартыг мөрдөх;<br>- “Хотын стандарт-Хүүхдийн тоглоомын талбайн ерөнхий шаардлага” UCS 1405B стандартыг мөрдөх;<br>- “Хотын стандарт-Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд байршуулах хогийн саванд тавих шаардлага” UCS 1406B стандартыг мөрдөх;<br>- “Хотын стандарт-Нийтийн эзэмшлийн талбайд сандалд тавих ерөнхий шаардлага” UCS 1407B стандартыг мөрдөх;<br>- “Хотын стандарт-Хашаа, хайс, хашлагад тавих ерөнхий шаардлага” UCS 1410B стандартыг мөрдөх;<br>- Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар (MNS6056:2009)<br>- “Хотын стандарт-Тээврийн хэрэгслийн ил зогсоолыг төлөвлөх, хучилтад тавих ерөнхий шаардлага” /UCS 0902B/<br>- Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНбД 30-01-04/;<br>- Барилгын орчны тохижилтын ажлын норм ба дүрэм /БНбД 3.01-06-90/;<br>- Барилгын төсөв зохиох дүрэм БНбД 81-95-12<br>- Бусад холбогдох норм, дүрэм;<br><br>Төсөл, хөтөлбөрүүд: |

| | | |
|---|---|---|
| | | - Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл;<br>- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр;<br>- Баянзүрх дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр; |
| 12 | Эдийн засгийн тооцоо, төсөв | - Төсвийг ESTIMATOR-PRO программ болон бусад зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцох; |

ХЯНАСАН:
ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН
УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА Д.ДАВААСАМБУУ

БОЛОВСРУУЛСАН:
ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Л.БАТБАЯР